



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/641

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.5 дахь заалт, 4 дүгээр 4.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 43 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг орон нутгийн аялал жуулчлалын үзэсгэлэнт газруудыг олон нийтэд сурталчлах хүрээнд хийгдсэн Сурталчилгааны самбарын хөл суурилуулсан бетон зуурмагийн төлбөр болох 3,050,000 (гурван сая тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л. Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. АМГАЛАНБААТАР